

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2018 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 12 дугаар сарын 27

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ			
1	2	3	4
1	<p>Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана:</p> <p>I үе шат (2016-2020): Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.</p>	<p>Нүүрс гүн боловсруулах үйлдвэрийн бэлтгэл ажлыг эхлүүлэх, үйл явцад дэмжлэг үзүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Нийт 812 сая тн нөөцтэй Багануурын хүрэн нүүрсийг гүн боловсруулж евро стандартын шатахуун, нийлэг хий, битум, кокс, дагалдах цэвэр ус, химийн бүтээгдэхүүн гарган авах боломжтой нь судалгаагаар тогтоогдсон. - Нүүрс шингэрүүлэх, нүүрснээс гумины болон хөрс сайжруулах бордоо үйлдвэрлэх төслүүдэд хөрөнгө оруулах - саналыг гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын форум, уулзалт, зөвлөгөөнүүдэд танилцуулан ажиллаж байна. - Одоогоор ХБНГУ-ын хөрөнгө оруулалттай “Монгол Шингэн нүүрс” ХХК-ийн нүүрс шингэрүүлж дизель түлш, битум, цэвэр ус, дулаан үйлдвэрлэх төслийг хүлээн авсан. - Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтэц одоогоор шийдвэрлэгдээгүй тул уг төслийн хөрөнгө оруулалт хүлээгдэж байна. - Паркийн ХЕТ болон дэд бүтцийн зураг төслийг боловсруулах ажил дуусах шатанд байна. 	100%
2	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр: 2.57 Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ.</p>	<ul style="list-style-type: none"> - БҮТП-ийн Хөнгөн ба хүнсний 218,5 га талбай бүхий бүсэд ноос ноолуур, сүү, мах болон модон бүтээгдэхүн үйлдвэрлэх 33 үйлдвэр байгуулах урьдчилсан ТЭЗҮ боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. - Хөнгөн үйлдвэрийн бүсэд ноос, ноолуур гүн боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийн төслийг хэрэгжүүлэх бөгөөд кластерын бүтцээр хонины ноосоор барилгын, техникийн болон ахуйн дулаалгын материалын үйлдвэрлэл, ээрмэл утас, сүлжмэл даавуу, хивсний үйлдвэрлэл хөгжүүлэхээр төлөвлөж байна. - Япон улсын хөрөнгө оруулалтаар Силкроуд Аёори Монгол ХХК нь “Ноос, 	100%

		<p>ноолуур гүн боловсруулах үйлдвэр"-ийн төсөл хэрэгжүүлэхээр 2016 онд салбарын Яам, НЗДТГ-тай санамж бичиг байгуулсан. Өнөөдрийн байдлаар төслийн нэгж хэрэгжүүлэх технологийн патент, лицензийн асуудлаас хөрөнгө оруулалт нь хойшилсон байна. Мөн түүхий эдийн үнэ тогтворгүй, огцом өссөнөөс шалтгаалан төслийн тооцооллыг дахин хийх шаардлагатай болсон байна. Жишээ нь: хонины ноос анх 500 төг байснаас 3500 төгрөг болж өссөн нь анхны хөрөнгө оруулалтын дүн өөрчлөгдөхөд хүргэсэн.</p> <p>- Гадаадын орнуудын кластерын зохион байгуулалтын туршлагауудыг судалж, кластерын бүтцэд хамруулахаар ААНБ-уудын судалгааг гаргасан. Паркийн кластерын удирдлагын системийн загварын төслийг боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон.</p>	
3	<p>НЗД-ийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр: 1.1.1.4 Багануур дүүрэгт "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" байгуулах ажлыг эхлүүлэх хөтөлбөрийн хүрээнд: Арга хэмжээ -1.1: <i>(Арга хэмжээний нэр, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин)</i> 1.4 "Багануур үйлдвэрлэл, технологийн парк"-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж батлуулан дэд бүтцийг бий болгох ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт болон гадна инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төслийг хийж гүйцэтгэх санхүүжилтийг БХБЯ-аар 100% шийдвэрлүүлэн эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэгч компанид БҮТП-ийн зүгээс шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж хамтран ажиллаж байна.</p> <p>2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №2018/10 тоот гэрээгээр "Мон-Энержи Консалт" ХХК нь Паркийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж байна.</p> <p>Эхний үе шат. Паркийн бүсэд хөрсний судалгааны дээж авч, талбайн дэвсгэр зургийн солбицлын цэгийг тодорхойлон үйлдвэрүүдийн байршил, бүсчлэлийн схем зураг, туслах болон гол замын трассыг дүүргийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх ажлыг зохион байгуулсан. Зураг төслийн гүйцэтгэлийн явцад хяналт тавьж эхлэлийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авсан. Үйлдвэрийн хэсэгт үйл ажиллагаа явуулж буй ААНБ тэдгээрийн байршлын талаарх урьдчилсан судалгаа зураглалыг гаргахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Урьдчилсан байдлаар Хөнгөн, хүнд, адуу брэнд, ургамал нано-биотехнологийн үйлдвэрлэлийн бүсчлэл, авто замын схем зургийг хүлээн авч, гүйцэтгэгч байгууллагатай хамтарсан уулзалт хийж ажлын явц тулгамдсан асуудал зэргийг хэлэлцэн дүүргийн мэргэжлийн байгууллагуудын удирдлагатай уулзалт хийж санал зөвлөмж авч дараах мэдээлэл материалыг хүргүүлэв.</p> <p>Үүнд :</p> <ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн урьдчилсан төлөвлөлтийн схем зураг 	100%

		<ul style="list-style-type: none"> • Ерөнхий төлөвлөгөөнд тусгах үйлдвэрүүдийн жагсаалт, Паркийн ТЭЗҮ-д тусгагдсан үйлдвэрүүдийн шинэчилсэн болон эмхэтгэсэн төслүүд • Багануур хотын дулаан хангамжийн үйлдвэрийн хэсгийн трасс шугамын схем зураг • Зураг төслийн ажил гүйцэтгэж байгаатай холбогдуулан мэргэжлийн байгууллагууд болох "Багануур -Ус" ОНӨААТҮГ, "Багануур дулааны станц" ТӨХК-иас авсан санал зөвлөмжүүд • Ерөнхий төлөвлөгөөнд тусгах шинээр ирсэн үйлдвэрүүдийн эмхэтгэсэн төслүүд • Мөн Багануур дүүрэгт зонхилох салхины чиглэл • "Монгол Шингэн Нүүрс" ХХК-ийн Нүүрс шингэрүүлэн дизель түлш үйлдвэрлэх төслийн үйлдвэрийн төлөвлөлтийн схем зураг <p>Дунд үе шат</p> <p>Хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд төлөвлөгдөж буй Европ стандартын барилгын үйлдвэрлэлийг ерөнхий төлөвлөгөөнд тусгах эсэхийг тодруулсан албан бичгийн дагуу гүйцэтгэгч байгууллага “Мон-Энержи Консалт” ХХК-д холбогдох мэдээлэл шийдвэрийг албан бичгээр хүргүүлсэн. Дүүргийн Үйлдвэрийн хэсэгт үйл ажиллагаа явуулж буй ААНБ тэдгээрийн байршлын талаарх урьдчилсан судалгааг зураг төслийн багийнхантай хамтран газар дээр нь явж үзүүлэн дүүргийн холбогдох байгууллагаас мэдээ, материал авч, үйлдвэрлэлийн бүсчлэл, авто замын схем, инженерийн шугам сүлжээний зураглалыг урьдчилсан байдлаар боловсруулсан.</p> <p>Гадна инженерийн шугам сүлжээний инженерийн эрэл хайгуулын ажил хийгдэж, паркийн бүсүүдийн гадна инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлийн талаар мэргэжлийн байгууллага болох БЗӨБЦТС ТӨХК, “Багануур Ус” ОНӨААТҮГ, МХС ТӨХХК, Багануур дулааны станц ТӨХК зэрэг байгууллагуудын мэргэжилтнүүдийн хамтаар урьдчилсан төлөвлөлтийг боловсруулсан.</p> <p>Газрын албаар дүүргийн 2030 он хүртэлх хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон одоо байгаа инженерийн шугам сүлжээний төлөвлөлтөд давхцал байгаа эсэхийг хянуулсан.</p> <p>Хөнгөн ба Хүнсний үйлдвэрлэлийн бүсийн дулаан хангамжийн эх үүсвэрийг төвлөрсөн дулаан хангамжаас шийдвэрлүүлэхээр Багануур дулааны станц ТӨХК, “Мон-Энержи Консалт” ХХК-ийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж шийдвэрлүүлэв. Цахилгааны урьдчилсан трасс шугам дүүргийн “Монгол наадам” цогцолбор болон Уурхайн ашиглалтын бүсээр давхцал үүсэж БЗӨБЦТС ТӨХК, БЗБЦД ТӨХК, “Багануур” ХК-ийн эрчим хүчний нэгдлийн холбогдох инженерүүд, зураг төслийн багийнхантай төлөвлөлтийн</p>	
--	--	--	--

		<p>бүсээр явж шинэчилсэн төлөвлөлтийг боловсруулж дүүргийн газрын албанд хүргүүлсэн.</p> <p>Төгсгөлийн үе шат. Паркийн бүсүүдэд МХС ХХК, Багануур Ус ОНӨААТҮГ–аас гаргасан техникийн нөхцөлийг захиалагчид хүргүүлэв. Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 134 дугаар тушаалаар Цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтыг 2019 оны 03 дугаар сарын 01 –ний өдрийг хүртэл түр зогсоох шийдвэр гарсантай холбогдож зураг төсөл гэрээт хугацаанд дуусах боломжгүй, удааширч байгаа тул манай байгууллага БХБЯ, УУХҮЯ, БХТ, НЗД зэрэг удирдах дээд байгууллагуудад дараах асуудлыг яаравчлан шийдвэрлүүлэхээр албан тоот хүргүүлэв.</p> <p>БХБЯ-ны экспертийн ерөнхий төлөвлөгөөнд өгсөн санал зөвлөмжийн дагуу зураг төсөлд нэмэлт өөрчлөлтийг тусган хариуцсан мэргэжлийн байгууллагуудаар баталгаажуулснаар Нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болж байна.</p>	
4	<p>Нийслэлийн Багануур дүүргийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр:</p> <p>Гурав. Баялаг бүтээгчдээ дэмжсэн, үйлдвэрлэл хөгжсөн хот</p> <p>3.1 Үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд нано технологи, аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, томоохон болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.</p> <p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 10 дугаар бүлэг: Биотехнологийн шинжлэх ухааны шилдэг техник, технологиудыг нэвтрүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Юуны түрүүнд БҮТП-ийн нийт 414,0 га газарт Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг 2014 оны А/117 дугаар тушаалаар батлагдсан аргачлалд заасан шаардлагын дагуу гүйцэтгүүлэх шаардлагатай байгаа тул мэргэжлийн “САТУ” ХХК-иар Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээг дахин хийлгэж байна. Ажлын тайланг 2019.01.10-нд хүлээж авах бөгөөд БОАЖЯ-нд хүргүүлж дүгнэлт гаргуулснаар Нарийвчилсан үнэлгээг 2019 оны 2 дугаар улиралд багтааж хийлгэх төлөвлөгөөтэй байна. • Паркийн үйл ажиллагааг сурталчлах, хөрөнгө оруулалт татах талд багагүй ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд сонгон шалгаруулж хэрэгжүүлэх төсөлд ТЭЗҮ, БОНБУ, ТТҮ-ийг заавал ирүүлэх шаардлагыг тавьж ажиллаж байна. 	100%

5	<p>Багануур дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл:</p> <p>1.10. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Хөрөнгө оруулагчдын таатай орчин” бизнес уулзалтад Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга Ч. Элбэгсайхан “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн төслүүдэд ААНБ, хувийн хэвшлийн оролцоог бий болгох нь” сэдэвт илтгэл тавьсан. Тус уулзалтад паркад элсэх хүсэлтэй 10 компанийн төлөөллийг урьж оролцуулсан. Мөн паркийн иж бүрэн танилцуулгыг Монгол-Англи, Монгол-Хятад хэл дээр бэлтгэн уулзалтад оролцогчдод хүргүүлэв. - Байгууллагаас 2 мэргэжилтнийг “Бүгд Найрамдах Буриад улс - Монгол улс”-ын бизнес чуулганд 2018 оны 5 дугаар сард оролцуулсан. Тус чуулганы үеэр Буриадын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор, аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцан холбоо тогтоож, туршлага судалсан. Тухайлбал импортыг орлох эко тоглоом үйлдвэрлэдэг “Наран” ХХК-ийн туршлагаар ижил төстэй үйлдвэр байгуулах санааг паркад байгуулахаар төсөлд тусгалаа. - БҮТП-н ХЕТ болон гадна инженерийн дэд бүтцийн зураг төслийг хийж гүйцэтгэх санхүүжилтийг БХБЯ-р 100% шийдвэрлүүлэн эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэгч компанид БҮТП-н зүгээс шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлэн, хяналт тавин хамтран ажиллаж байна. - 2019 онд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг ЗГ-н концессоор эхлүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 	100%
6	<p>Багануур дүүргийн төр захиргааны байгууллага, БҮТП ОНӨТҮГ хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5 дугаар заалт:</p> <p>“Боловсролын хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонгоход нь туслах арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>“Боловсролын хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд “Боловсрол цогцолбор”, “Гүн-Галуутай” сургуулиудын төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонгоход нь туслах зорилгоор паркийн 3 мэргэжилтэн инженерчлэлийн чиглэлээр суралцах 60 гаруй сурагчдад мэргэжлийн онцлог, гүйцэтгэх ажлын талаар зөвлөгөө өгсөн.</p> <p>ЗГ-ын хэрэгжүүлэгч агенлаг Оюуны Өмчийн Газартай хамтран зохион байгуулсан “Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулан хөрөнгө болгоё” сэдэвт сургалтанд ерөнхий боловсролын 17 багш сурагчдыг урилгаар хамруулж оюуны өмчийн талаар анхны мэдэгдэхүүн өглөө .</p>	100%
ХОЁР. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ			
1	2	3	4
7		<p>Монгол улсын Засгийн газрын тогтоолоор “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаар батлагдсаны дагуу төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т заасны дагуу 2019 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөллийг хүргүүлсэн.</p> <p>Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай Монгол улсын Засгийн газрын</p>	100%

	Засгийн газрын тогтоол	тогтоолын хэрэгжилтийн хүрээнд БҮТП нь 2015 оны 07 дугаар сард байгуулагдсан бөгөөд тус байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтан байхгүй, цаашид боломж бүрдмэгц Ахмадын сан байгуулж ажиллуулах тухай мэдээллийг БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 117 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	
		Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд эрчимжүүлэх, бүх түвшинд хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд эцэг эхийн зөвлөл байгуулан, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна	100%
		“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 01 албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна.	
		“Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
		Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж манай байгууллагын ажилтан албан хаагчид албаны интернет сүлжээгээр олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын видео сан бүхий сайтууд /Facebook, twitter, youtube, instagram, steam/ ашигладаггүй болсон.	
8	Нийслэлийн Засаг даргын захирамж	Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамж “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлж байна.	100%
		НЗД-ын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар захирамжийн дагуу 2018 оныг “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарласны хүрээнд тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүргүүлсэн.	
		НЗД-ын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/86 дугаар захирамж “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүргүүлсэн.	
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН			
1	2	3	4
9	БҮТП ОНӨТҮГ-ын дүрмээр хүлээсэн	▪ Европ стандартын барилгын үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгч “Ий Пи	

	<p>чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа Арга хэмжээ-2.1: <i>(Арга хэмжээний нэр, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин)</i> БҮТП ОНӨТҮГ-ын Дүрмийн 2.8: Хуульд зааснаар паркт байрлах аж ахуйн нэгжүүдийг батлагдсан чиглэлийн дагуу дээд байгууллагуудтай хамтран сонгон шалгаруулах</p>	<p>Эм” ХХК-с ирүүлсэн төсөлтэй нь танилцаж хөрөнгө оруулалт нь баталгаажтал хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Багануур сүү ХХК-иас ирүүлсэн Европ стандартын бяслаг боловсруулах үйлдвэрийн төсөлтэй танилцан дэмжиж төсөлд тодруулга авах тухай бичгийг тус компанид хүргүүлсэн. ▪ Зарим ААНБ-ын ирүүлсэн төсөл нь хараахан шаардлага хангаагүй байв. Үүнд: Цэц консалтинг ХХК ба Хатант интернэйшнл ХХК-ийн Ноос самнах, хялгас ялгах үйлдвэрүүдийн төслүүдийг шинэчлэж ирүүлэхээр буцаав. ▪ Паркийн зураг төсөл, ерөнхий төлөвлөгөө шинэчлэгдэж байгаатай холбогдуулан шинээр байгуулах 3 үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулав. Үүнд: Гурил тэжээлийн үйлдвэр, зоорины аж ахуй болон хүлэмжийн аж ахуй. <p><i>Татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг үзүүлэх журам заавруудыг гаргах асуудлыг дээд байгууллагад тавьж хэрэгжүүлэх:</i></p> <ul style="list-style-type: none"> ▪ Татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг үзүүлэх журам заавруудын талаар суурь судалгаа хийсэн. ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгасан байдлаар зарим хөнгөлөлт чөлөөлөлтийн хууль тогтоомжийн үйлчлэл дуусгавар болсон байдаг байна. ▪ ҮТП-ийн Эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт Паркийн дарга ажилласан бөгөөд хуулийн шинэчилсэн төсөл боловсруулагдаж дууссан бөгөөд УИХ-аар хэлэлцүүлэн батлагдсаны дараа төрийн захиргааны холбогдох байгууллагууд журам шийдвэрээ боловсруулан гаргах юм. 	100%
10	<p>БҮТП ОНӨТҮГ-ын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа Арга хэмжээ-3.1: БҮТП ОНӨТҮГ-ын Дүрмийн 3.1.1: БҮТП нь байгууллагын санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, төсөв болон үйл ажиллагааны орлогыг дүрэмд заасан үйл ажиллагаа, батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зарцуулах</p>	<p><i>3.1.1.1 Нийслэлийн Засаг даргатай контракт байгуулж, өмчийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, зорилтот түвшинг биелүүлж ажиллах</i></p> <ul style="list-style-type: none"> - БҮТП-ийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан орлого болон зарцуулалтыг зорилтот түвшинд ханган ажиллаж байна. - НЗД-тай байгуулсан 2017 оны контрактын гэрээг НӨХГ-тай болон тусгай зөвлөлийн хүрээнд хамтран дүгнэсэн. 	100%
11	<p>3.0. БҮТП ОНӨТҮГ-ын 2017-2025 оны Стратеги төлөвлөгөөний 2018 оны</p>	<p>Хөрөнгө оруулалтын менежментийг сайжруулах замаар өндөр технологийн экспорт, импортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих: - Экспортын болон импортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих</p>	100%

	<p>үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах Арга хэмжээ -3.1: <i>(Арга хэмжээний нэр, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин)</i></p>	<p>бодлогыг хэрэгжүүлэх үүднээс “Монхимо”, “Монгол Шингэн нүүрс”, “Силкроуд Аёори Монгол” компаниудын удирдлагуудтай байнгын холбоотой ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - “Силкроуд Аёори Монгол” ХХК-ийн төслийн ТЭЗҮ-ийн боловсруулалт эцсийн шатандаа хийгдэж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн патент, лицензийн асуудлаас хамааран удааширч байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай байнгын холбоотой мэдээ, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. - “Монхимо” ХК-ын “Адуу” бренд төслийн өргөтгөлийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын 21-100 хөтөлбөрийн хүрээнд шийвэрлэсэн боловч санхүүжилт шийдэгдээгүй байна. - “Монгол Шингэн нүүрс” төслийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй байгаагаас хүлээлтийн байдалд байна. /Төслийн нэгжийн газраас/ 	
<p>12</p>	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр бүлэг: Паркийн удирдлага, засаглалыг төлөвшүүлнэ.</p>	<p>Паркийн удирдлага, засаглалыг төлөвшүүлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Стратегийн удирдагчийн тодорхойлолтыг гарган мөрдөж байна. - “Парк – Суралцагч байгууллага” болох зорилтын хүрээнд байгууллагын нийт ажилтнууд суралцах чиглэлээ тодорхойлон мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдахын зэрэгцээ бие даан суралцаж байна. Паркийн шийдвэрлэх асуудлуудад ажилтнууд өөрсдийн санал бодлоо дэвшүүлэн оролцдог идэвхитэй байдал тогтож эхэлж байна. - Паркийн кластерын удирдлагын тухай мэдлэгтэй болох зорилгоор гадаадын орнуудын кластерын зохион байгуулалтын туршлагууд судалж, кластерын бүтцэд хамруулах ААНБ-уудын судалгааг гаргасан. - Паркийн кластерын удирдлагын бүтцийн загварын төслийг боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон. 	<p>100%</p>
<p>13</p>	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2 дугаар бүлэг: Паркийн хөгжлийг хангахуйц хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/757 дугаар захирамжийг үндэслэн Газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар БҮТП ОНӨТҮГ-ын ажиллагсдын бүтэц, орон тоог баталж мөрдөн ажиллаж байна. Паркийн үйл ажиллагаа тэлж байгаатай уялдуулан удирдлага зохион байгуулалтын бүтэц болон ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллаж байна <p>Хүний нөөцийн чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөрийг батлуулан, мөрдөн ажиллаж байна. Үүнд: 1. Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт; 2. Мэргэшсэн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх;</p>	<p>100%</p> <p>100%</p>

		<p>3. Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх; 4. албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлсэн байдал; 5. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тус тус арга хэмжээ авч ажилласан.</p>	
		<p>2018 оны 2 дугаар сард байгууллагын ажилтнуудын ажлын ачааллын зураг авалт зохион байгуулж, ажлын байрны тодорхойлолттой нийцэж байгаа эсэхийг хянан шалгаж баталгаажуулсан.</p>	100%
		<p>Хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу паркийн ажилтан нараас аттестатчиллын шалгалтыг ажил мэргэжил, хууль эрх зүй, ХАБЭА, бичиг хэрэг архивтай холбоотой чиглэлээр авах бэлтгэл ажлыг хангаж сарын эцсээр авахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	100%
14	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 дугаар бүлэг: Харилцаа, хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.</p>	<p>Олон улсын төсөл, хөтөлбөрт хамрагдах, засгийн газрын дэмжлэг авах боломж гарцуудын талаар судалсан.</p> <p>1. БНХАУ-ын Бээжин хотноо Монголын Эдийн засгийн хамтын ажиллагаа нийгэмлэг, БНХАУ-ын “Аж үйлдвэрийн холбоо” нийгэмлэг болон БНХАУ дахь Монгол Улсын ЭСЯ хамтран “Нэг бүс ба нэг зам төслийн Монгол дахь боломж” сэдэвт хөрөнгө оруулагчдын форумыг 2018 оны 03 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион оролцож Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн танилцуулга хийж, “Нэг бүс ба зам” төслийн хүрээнд хөрөнгө оруулагч түншүүдтэй холбоо тогтоож, Хүнд үйлдвэрлэлийн болон биотехнологийн салбарт хамтран ажиллах мөн Бээжин хотын эдийн засаг технологийн паркттай танилцаж туршлага судлах зорилготой ажилласан.</p> <p>2. Багануур дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Хөрөнгө оруулагчдын таатай орчин” бизнес уулзалтыг хамтран зохион байгуулж, паркад элсэх хүсэлтэй 10 компаний төлөөлөлийг урьж оролцуулав. Мөн паркийн иж бүрэн танилцуулгыг Монгол-Англи, Монгол-Хятад хэл дээр бэлтгэв. “Монхимо” ХК-ийн бүтээгдэхүүн болон Уурхайн нүүрс дагалдах эрдсийг ашиглах судалгааны материал, биет үзүүлэнг тавьж сурталчлав. “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн төслүүдэд ААНБ, хувийн хэвшлийн оролцоог бий болгох нь” сэдэвт илтгэлийг дарга Ч.Элбэгсайхан тавив.</p> <p>3. Зах зээлийн хөгжил дэвшил, дэлхийн инноваци, дэвшилтэт техник технологийн талаар танилцуулах “EXPO MONGOLIA” олон улсын үзэсгэлэн 2018 оны 10 дугаар сард зохион байгуулагдаж манайх хөрөнгө оруулагчдыг татах, паркийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг</p>	<p>100%</p> <p>100%</p>

		<p>хөрөнгө оруулагч, үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргэх зорилготойгоор оролцсон.</p> <p>4. Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С. Батболдын 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/780 дугаар захирамжийн дагуу БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөх хотод зохион байгуулагдсан “Монгол- Хятадын хөрөнгө оруулалтын форум”-д байгууллагын дарга оролцож, “БҮТП-ийн дэд бүтэц бүтээн байгуулалт төсөл”-ийг танилцуулсан.</p>	
15	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар бүлэг: Төслийн иж бүрэн удирдлагын стандартыг нэвтрүүлнэ.	MNS, ISO - 21500 төслийн удирдлагын стандартыг байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээнд судалж, хөрөнгө оруулагчдын төсөлд тавих шаардлагын түвшинд мөрдөж ажиллаж байна.	100%
16	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 6 дугаар бүлэг: Эрсдлийн удирдлагыг цогцоор хэрэгжүүлнэ.	Паркийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг судалсан. Үүнд улс төр, хөрөнгө оруулагч, хүний нөөц, төсөв санхүү, дэд бүтцээс хамаарсан эрсдэлийн шалтгааныг тодорхойлсон.	100%
17	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8 дугаар бүлэг: Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулж инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	<p>Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр судалгааны ажлыг явуулж инновацийн төслүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллах хүрээнд: БҮТП-ийн нэгж болох ШУУ-ийн “Монхимо” ХК-ийн “утаагүй нүүрс” төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, салбарын яам болон Засгийн газарт уламжлан хүргүүлж ажиллаж байна. Энэхүү төсөл хэрэгжвэл Багануурын нүүрсийг Солонгос улсын өндөр технологи ашиглан хорт утааг багасгаж, экологийн шаардлага хангасан нүүрс цэвэршүүлэх боломж бүрдэнэ.</p> <p>Техник технологи, ШУ-ны мэдээллийн судалгаа явуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжуудыг тодорхойлж төлөвлөгөөтэй ажиллах хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэл технологийн албаны ажилтнууд Евро стандартын барилгын шинэ Техник технологи, Шинжлэх ухааны мэдээллийн талаар судалгаа хийж, Багануурын уурхайн дагалдах шороон овоолгыг энэхүү салбарт ашиглаж болох технологийг инновацижуулах боломжийг эрэлхийлж байна. 2. “Ий Пи Эм” ХХК-ийн төсөл дээрх судалгаанд тохиромжтой гэж үзэж байгаа бөгөөд Хөрөнгө оруулагчидтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулж байна. 3. Хими, хими технологийн хүрээлэнгийн шинэ материалын сорилын лабораторын удирдлага хамт олонтой хамтран ажиллах талаар гурван талын оролцоотой уулзалтыг “Багануур” ХК дээр 10 сард зохион байгуулж, уурхайгаас нүүрс, исэлдсэн хэсгээс сорилын дээж авах ажлыг уурхайн инженерийн хамтаар гүйцэтгэв. Тус лабораторын 	100%

		<p>шинжилгээний тайланг хүлээн авч танилцав.</p> <p>4. Паркийн хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу тус паркийн дэргэд үйлдвэрлэл ба бизнес эрхлэгчид, шинжлэх ухааны ажилтнуудын хамтын ажиллагааг шинэ, шилдэг техник технологийг нэвтрүүлэхэд чиглүүлж бүтээлч нэгдмэл үйл ажиллагааг өрнүүлэх зорилгоор паркийн инкубатор, инноваци, судалгаа төвийн/ ПИИСТ/ төслийг боловсруулж, дуусгах шатанд явж байна.</p> <p>5. ПИИСТөвд инкубаторууд байгуулах төсөлд ФТХүрээлэн, ГУУИС, МУИС-ийн физикийн тэнхим, ХХТИ-ийн, профессор, докторуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх гурван талын оролцоотой уулзалтыг “Багануур” ХК дээр 11 дүгээр сард зохион байгуулсан. Уурхайн хөрсний шороо, нүүрснээс тандалтын урьдчилсан дээжүүдийг авав. Хамтран ажиллах боломжийг тодорхойлох гурвалсан уулзалтыг энэ сарын 19-ны өдөр МУИС дээр хийхээр товлоод байна.</p> <p>6. Монголын Оюуны Өмчийн Газартай хамтран 2018 оны 11 дүгээр сард Дүүргийн ЗДТГ-ын хурлын танхимд “Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулж хөрөнгө болгоё” сэдэвт сургалтыг 13-н байгууллага, жижиг дунд болон өрхийн үйлдвэр эрхлэгч, иргэдэд явуулж, хэлэлцүүлэг зохион байгуулав. Тус сургалтыг дараах сэдэвүүдээр явуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Патентын тухай хууль ▪ Байгууллагадаа албан үүргээ гүйцэтгэж байхад гаргасан оюуны өмчийн мэдүүлгийг хэрхэн шийдвэрлэх ▪ Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль ▪ Зохиогчийн эрхийн тухай хууль ▪ Шинэ бүтээлийн мэдүүлэг бүрдүүлэх талаар ▪ Ашигтай загварын мэдүүлэг бүрдүүлэх талаар ▪ Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг бүрдүүлэх талаар ▪ Барааны тэмдгийн мэдүүлэг бүрдүүлэх талаар ▪ Газар зүйн заалтын мэдүүлэг бүрдүүлэх тухай ▪ Оюуны өмчийн менежментийн тухай ▪ Оюуны өмчийн үнэлгээний тухай ▪ Оюуны өмчтэй холбоотой төлбөр хураамж 	
		<p>Үндэсний уламжлалт технологи болон гадаадад жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр Өндөр технологи эзэмшсэн иргэд гарааны хөрөнгөгүй, ажлын байхгүйн улмаас үйлдвэрлэл эрхэлж чадахгүй байна. МУ-н ҮТП-н эрх зүйн байдлын тухай хуулинд болон БҮТП-н үйл ажиллагааны үндсэн зорилгод өрхийн болон ЖДҮ-г дэмжин хөгжүүлэх заалтууд тусгагдсан байдаг. Тийм учраас Паркийн хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд өндөр технологийн ЖДҮ-г бойжуулах төв байгуулах төсөл боловсруулсан бөгөөд барилгын зураг төслийг бүтээх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нь дээрх зорилтуудыг</p>	<p>100%</p>

		хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс Паркийн дэргэд инкубатор инноваци судалгааны төв байгуулах/ ПИИСТ/ төслийг боловсруулж байна.	
		<p>8.4.Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулж инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Паркийн дэргэд туршилт судалгаа, зохион бүтээх төв байгуулах ажлыг судалж байна. Аливаа Аж үйлдвэрийн паркийн дэргэд эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт ба инновацийн төв хамтран ажиллах зайлшгүй шаардлага байна. - Гар хивсний урлалын талаар судалгаа хийж, хөгжүүлэх арга замыг тодорхойлсон. Хөнгөн үйлдвэрийн бүсэд гар хивснээс гадна олон төрлийн ЖДҮ-ийг хөгжүүлж болох судалгааны ажлуудыг гүйцэтгэж, холбогдох тооцоо зураг төслийг хийж байна. 	100%
18	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 9 дугаар бүлэг: Монгол улсад био эдийн засгийн салбарыг тэргүүлэн хөгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Паркад ургамлын биотехнологийн үйлдвэрлэлийг байгуулах суурь судалгааг явуулж төлөвлөгөөтэй ажиллах хүрээнд Паркийн ургамал нано-биотехнологийн бүсэд 100 м2 газартай туршилт судалгааны талбай байгуулах төсөл боловсруулсан. Төслөөр Эгэл годил (<i>Acorus calamus</i>), Монгол алтан хундага (<i>Adonis mongolia</i>), Дэлт харгана (<i>Caraganajubata</i>) гэх зэрэг ховор, ховордсон ургамал тариалж нутагшуулах туршилтуудыг явуулна. - Биотехнологийн бүсэд компост бордооны үйлдвэр байгуулах тул гэр, ахуйн хаягдлаар компост, эрдэст бордоо хийх сургалтыг дүүргийн 5 хороодод урьдчилан явуулж иргэдийн биотехнологийн талаарх мэдлэгийг дээшлүүлж бордоо хийх арга эзэмшүүлэх алхам хийв. 	100%
19	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 10 дугаар бүлэг: Биотехнологийн шинжлэх ухааны шилдэг техник, технологиудыг нэвтрүүлнэ.	“Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн дагуу “Монхимо” ХХК-иас биологийн идэвхт, органик бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн үйлдвэрлэх, ард иргэдийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийлүүлэх талаар хамтын ажиллагааны төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна. Адуу брэндийн кальци бусад нэр төрлийн бэлдмэлүүд дотоодын зах зээлд нэвтэрч эрэлт хэрэгцээт бүтээгдэхүүн болсон.	100%
20	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 11 дүгээр бүлэг: Жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл хөгжих орчныг бүрдүүлнэ.	<p>Дүүргийн жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх, дэмжих арга хэмжээг Дүүргийн ҮҮХ, ЖДҮ –тэй хамтран төлөвлөгөөтэй ажиллах хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ ЖДҮ эрхлэгчдийн судалгааг гаргав ▪ Биотехнологийг плантац байгуулах эх суурийг тавих нээлттэй өдөрлөг зохион байгуулсан. ▪ МХАҮТ-аас 5 дугаар сард зохион байгуулсан Монгол-Буриад улсын бизнес форумд ЖДҮ эрхлэгчдийн хамтаар оролцсон. ▪ Оюуны Өмчийн газартай хамтран зохион байгуулсан Оюуны Өмчийн сургалтанд ЖДҮ эрхлэгчдийг хамруулах арга хэмжээг авлаа. 	100%

		<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газраас зохион байгуулсан “Дагуул хотуудын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг туршлага судлуулах” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн ЖДҮ-д, ДБҮҮХ-ийн мэргэжилтэнүүдтэй хамтран Улаанбаатар хотын “Говьхангай мебель” ХХК-ийн үйлдвэр, “Эвсэг кашмер” ХХК-ийн үйлдвэр, “Санкотэк Монголиа” ХХК-ийн үйлдвэр, “Мон Лабел” ХХК-ийн үйлдвэрүүдтэй танилцлаа. 	
21	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 12 дугаар бүлэг: Өндөр технологид суурилсан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.</p>	<p><i>Экспортын болон импортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтлах хүрээнд:</i></p> <ul style="list-style-type: none"> - Паркийн нэгж “Монхимо” ХХК-ийн “Адуу” брэндийн бүтээгдэхүүнүүд нь орчин үеийн нанобиотехнологийн аргаар гарган авч байгаа үйлдвэрлэл юм. Энэхүү бүтээгдэхүүнийг дотоодын зах зээл гарахаас гадна ОХУ болон Хятад улсын зах зээлд гаргах үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж байна. Мөн ноос гүн боловсруулах”, “Нүүрс гүн боловсруулах” үйлдвэрүүдийн төслүүдийг хэрэгжүүлэхээр дэмжин ажиллаж байна. - Европ стандартын барилгын материал үйлдвэрлэлийн төслийг хүлээн авч технологитой танилцан дэмжиж хамтран ажиллах санамж бичиг байгуулав. - Евростандартын баяслаг үйлдвэрлэх төслийн технологитой танилцаж дэмжихээр ажиллаж байна. 	100%
22	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 13 дугаар бүлэг: Зүүн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд паркийн үйл ажиллагааг чиглүүлнэ.</p>	<p>Төрөөс нэгж үйлдвэрүүдэд үзүүлэх хөнгөлөлтийг хэрэгжүүлэх журмыг гаргуулах асуудлыг дээд удирдах байгууллагад тавьж шийдвэрлүүлэх хүрээнд: ҮТП-н эрх зүйн байдлын тухай хуульд дээрхи хөнгөлөлт чөлөөлөлтийн хэлбэр, хувь, хугацааг тодорхой зааж оруулж өгсөн.</p> <p>Үйлдвэрийн түүхий эд материалыг орон нутгаас хангах зохицуулалт хийх замаар дүүргийн ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих бодлогын хүрээнд паркийн угтвар ажлын төлөвлөгөөг мөрдөж байна.</p> <p>Эдийн засаг, нийгмийн байдалд үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж бэлтгэсэн.</p>	100%

23	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 14 дүгээр бүлэг: Байгаль орчинд халгүй, хаягдалгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг голлон дэмжинэ.</p>	<p>Байгаль цаг уурын онцлогын судалгааг бэлтгэх, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт гаргуулах хүрээнд: Паркийн газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажлыг Гранд-Амур ХХК-тай гэрээ байгуулж, 2018.06.07-ны өдөр ажил хүлээлцэх актаар хүлээн авсан.</p> <p>Паркийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд: Дүүргийн ойн сангаас хаягдлыг ашиглах боломжийг тодорхойлох судалгааг ой хамгаалагчтай хамтран хийж “Ойгоос ашиглах хаягдал их байна” гэсэн дүгнэлт, тайланг Нийслэлийн Байгаль Орчны Газарт хүргүүлэв. - ЗДТГ-ын ДБҮҮХ, ЗАА, Багануур ҮТП хамтран “Багануур үйлдвэрлэл технологийн паркад биотехнологийг хөгжүүлэх нь” сэдэвт ажлын хүрээнд дүүргийн 5 хорооны иргэдийг хамруулан ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үзүүлэх сургалтыг төлөвлөгөөний дагуу 9,10 дугаар сард явуулсан. Паркийн зүгээс бордооны боловсрох явцад тогтмол хяналт тавьж байна. - Паркийн биотехнологийн плантацийн баруун хил заагт хог хаягдал үүссэнтэй холбогдуулан хэмжилт хийж цаашид нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний төсөл боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. - Үйлдвэрийн хог хаягдлыг ашиглах хүрээнд Багануурын цахилгаан механикийн үйлдвэрийн төмрийн хягдал хэрчидэсүүдийг ашиглаж бүтээгдэхүүн хийх боломжийг судаллаа.</p>	100%
24	<p>БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 15 дугаар бүлэг: Хөрөнгө оруулалтын менежментийн бодлогыг сайжруулах</p>	<p>Хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх хүрээнд: Зах зээлийн хөгжил дэвшил, дэлхийн инноваци, дэвшилтэт техник технологийн талаар танилцуулах “EXPO MONGOLIA” олон улсын үзэсгэлэн 2018 оны 10 дугаар сард зохион</p>	100%

	замаар парсад үйлдвэрүүдийг байгуулах арга хэмжээ авна.	байгуулагдсан. Манай паркаас хөрөнгө оруулагчидыг татах, байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагч, үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргэх зорилготой оролцсон.	
25	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17 дугаар бүлэг: Паркийн нэгжийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах тогтвортой бодлогыг хэрэгжүүлнэ.	ҮТП-ийн хуулийн хүрээнд нэгжүүдтэй гэрээ байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах хүрээнд: БҮТП-ийн Ургамал-нанобиотехнологийн бүсэд төсөл хэрэгжүүлэх “Монхимо” ХХК-тай нэгжийн гэрээ болон газар ашиглалтын гэрээ байгуулсан. Адуу бренд төсөл нь шинжилгээ судалгаа ба үйлдвэрлэлийг 2011 оноос хойш тогтвортэй явуулж байна.	100%
26	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 18 дугаар бүлэг: Санхүүгийн төлөвлөгөө тайлангийн хяналтыг сайжруулж, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлнэ.	<i>Паркийн мөнгөн хөрөнгийн үйл ажиллагааг зохицуулах бодлогыг боловсруулж төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх хүрээнд:</i> Байгууллагын төсөв санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллахаас гадна НББ-н олон улсын стандартыг чанд мөрдөн ажиллсны үр дүнд 2016, 2017 онд Аудитын зөрчилгүй гэрчилгээ гардаж авсан. 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллаа.	100%
27	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 19 дүгээр бүлэг: Паркийн үйл ажиллагааг өргөтгөх замаар санхүүгийн бие даасан байдлыг хангах урт хугацааны бодлогыг баримтлана.	19.1. Паркийн үйл ажиллагааг өргөтгөх замаар санхүүгийн бие даасан бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд: хөгжлийн стратегийн төлөвлөгөөний дагуу дараах анхан шатны суурь судалгааг гүйцэтгэсэн. Үүнд: - Паркийн эзэмшил газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар “Парк хөгжүүлэх сан” байгуулж арившуулах тухай төсөл боловсруулсан, - Паркийн нэгжүүд, ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж болох нийтлэг төлбөртэй үйлчилгээнүүдийн судалгаа, - Паркийн инкубатор, инноваци, судалгааны төвийн дэргэд зохион бүтээх товчоо байгуулснаар инновацийн бүтээгдэхүүн гаргаж борлуулснаар хуримтлал үүсгэх	100%
28	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 20 дугаар бүлэг: Хамт олны нийгмийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тогтоож хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	20.1. Ажлын байрны стандарт, спорт эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн асуудлыг төлөвлөгөөний дагуу шийдвэрлэх 1. Дүүргийн хэмжээнд зохиогдох спорт эрүүл мэндийн календарьчилсан арга хэмжээний мэдээллийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. 2. Ажлын байрны стандарт, спорт эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%

29	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 21 дүгээр бүлэг: Нийгмийн хариуцлагын хөгжлийн бодлогыг баримтална.	<p><i>Паркийн нийгмийн хариуцлагын хөтөлбөр боловсруулж төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх</i></p> <p>Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн паркуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажлын туршлага, санал солилцох, сургалт мэдээлэл өгөх ажлынхүрээнд 2018 оны 11 сарын 22-ны өдөр Багануурын үйлдвэрлэл, технологийн паркт зохион байгуулсан тус хэлэлцүүлэгт НҮИГ-ын ажилтнууд, Эмээлтийн хөнгөн үйлдвэр, Налайхын барилгын материал, Багануурын үйлдвэрлэл, технологийн паркуудын мэргэжилтнүүд оролцлоо.</p>	100%
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ			
31	БҮТП ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7 дугаар бүлэг: Удирдлага, хяналт мэдээллийн боловсронгуй систем бүхий хөтөлбөр хэрэгжүүлнэ.	<p>“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн дагуу байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт дараахь мэдээллийг тогтмол шинэчлэн хөтлөн ажиллуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтэц - Байгууллага, иргэдтэй харилцах ажилтны бүрэн мэдээлэл болон байгууллагын удирдлагуудын иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь - БҮТП-д хандаж төсөл хөтөлбөр танилцуулахад шаардагдах баримт бичгийн бүрдэлийн жагсаалт - Төсөл хэрэгжүүлэх сонирхолтой өрхийн болон ЖДҮ эрхлэгчдийн судалгаа авах тухай - Санхүүгийн гүйцэтгэлийн сар бүрийн тайлан - Байгууллагын даргын тушаалууд - Байгууллагын бүтэц орон тоо, хүний нөөцийн талаарх мэдээлэл 	100%
ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ			
32	Холбогдох чиг үүргийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> - БҮТП-ийн үйл ажиллагааг нээлттэй хүртээмжтэй танилцуулах, хамтран ажиллах зорилгоор МХАҮТ-ын гишүүнээр элсэж, холбогдох чиг үүргийн хүрээнд сургалт хөтөлбөрт оролцож, ХОФ-дад танилцуулага тогтмол хийж байна. - НЗДТГ болон НИҮГ-т үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаанд нь тогтмол хүргүүлж ажиллаж байна - НӨХГ-т УУХҮЯ-ны мэдэлд байгаа БҮТП байгуулахад зориулан худалдан авсан газрыг объектын хамтаар шилжүүлэн авах асуудлыг тавьснаар яам нийслэлээс томилогдсон объект хүлээлцэх ажлын хэсэг ажиллаж байна. - 2019 онд Паркийн дэд бүтцийг барих хөрөнгө санхүүгийн шаардлагатай 	100%

		<p>урьдчилсан тооцоог хийж улс, нийслэлийн төсөвт тусгахаар хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - ҮХГ-т боловсруулан ЗГ-т баталсан 2018-2021 онд улсын хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх хөтөлбөрт Паркийн дэд бүтцийг барих төслийг оруулав. - НӨХГ-т НЗД-тай байгуулсан 2017 оны контрактын гэрээг хамтран дүгнэж, НЗД-ын зөвлөлд оруулах саналаа хүргүүлсэн. 	
33	Иргэд, ААНБ-аас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны хүрээнд	<p>1. БҮТП-д төсөл хэрэгжүүлэх хүсэлтээр дараах саналууд ирүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Европ стандартын барилгын үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгч “Ий Пи Эм” ХХК санал гаргасан, тухайн төсөлтэй нь танилцаж хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. - Багануур сүү ХХК-иас ирүүлсэн европ стандартын бяслаг боловсруулах үйлдвэрийн төсөлтэй танилцан дэмжиж төсөлд тодруулга авах бичгийг тус компанид хүргүүлсэн. <p>Зарим ААНБ-ын ирүүлсэн төсөл нь хараахан шаардлага хангахгүй байна. Үүнд: Цэц консалтинг ХХК, Хатант интернэйшнл ХХК-ийн ноос самнах, хялгас ялгах үйлдвэрүүдийн төслүүдийг шинэчлэн боловсруулж ирүүлэхээр буцаав.</p> <p>2. Иргэдээс байгууллагад гаргасан өргөдөл гомдол ирээгүй. Байгууллагын удирдлагын зүгээс иргэдтэй дараах асуудлаар ярилцаж санал, зөвлөмж солилцсон:</p> <ul style="list-style-type: none"> ▪ БҮТП-ийн хөрөнгө оруулалтын талаар тодорхой мэдээлэл өгч, Мөнгөнморьт сумаас мод боловсруулах ЖДҮ-ийн хэрэгцээнд байгалийн ойн унанги модыг ашиглах боломжтой төслүүдийн тухай ▪ Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт олборлож байгаа байгалийн битум тосыг БҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд буюу автозам байгуулах хэрэгцээнд ашиглаж болох талаар ярилцаж, 2019 оны хавар дахин уулзалт зохион байгуулахаар товлов. ▪ БНХК-ийн олборлолтын овоолго шороог шинжлэн судлах талаар хамтран ажиллахаар шийдвэрлэж, эхний ээлжинд судалгаанд зориулан цэгүүдээс 10-15кг дээж авсан. ▪ БҮТП-д ЖДҮ болон өрхийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих талаар Паркийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын талаар тайлбарлаж, санал солилцов. 	100%
34	Үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар	<ul style="list-style-type: none"> - Улс орны эдийн засаг хүндрэлтэй, төсвийн хэмнэлт хийж байгаа энэ цаг үед Паркийн бүтээн байгуулалт удаашрах төлөвтэй байна. - БҮТП-ийн ХЕТ, гадна инженерийн дэд бүтцийн иж бүрэн зураг төслийн гүйцэтгэлийн ажилд хяналт тавьж хамтран ажиллана. 	100%

		<ul style="list-style-type: none"> - Гэрээт ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж хүлээн авах нь чухал учраас НЗДТГ-ын холбогдох газар хэлтэсээс БХБЯ болон БХГ-тай хамтран ажиллах шаардлага байна. - Парк хөгжүүлэх сан байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх - Паркийн эзэмшил газрыг төслийн нэгжид олгохдоо нэг удаагийн төлбөртэй болгох ингэснээр ПХС-д суурь хөрөнгө босгох саналыг НЗД болон НИТХ-н түвшинд хэлэлцэж шийдвэрлэх - УУХУЯ-ны харьяанд байгаа БҮТП-ийн захиргааны зориулалттай барилга болон газрыг шилжүүлэн авах талаар тус яаманд санал тавьсан. Улмаар Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэхээр тус яамнаас ТӨХ-д хүргүүлсэн байгаа. Уг асуудлыг НӨХГ-аас тосон авч шийдвэрлэж өгөх - БҮТП-д ЖДҮ-ийг дэмжих хөгжүүлэх инкубатор төв байгуулах төслийг боловсруулж байна. Энэхүү төслийг холбогдох газраар хэлэлцүүлэн дэмжиж, зураг төслийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх - Байгууллагын ИТА-дыг мэргэшүүлэх сургалт, дамжаа, хөтөлбөр, төсөлд оролцуулах - 2018-2021 онд УХО-аар хийж гүйцэтгэх хөтөлбөрт БҮТП-ийн дэд бүтцийн санхүүжилтийг тодорхой хуваарьтай оруулсан байгаа. Одоогоор зураг төсөл бүрэн хийгдээгүй шалтгаанаар эх үүсвэрийг нь шийдвэрлээгүй 11 төсөлд оруулсан байна. Зураг төслүүд энэ оны 9-10-р сард эцэслэн бэлэн болох тул 2019 оны төсөвт эхний хуваарьт санхүүжилтийг тусгуулах талаар тодорхой дэмжлэг үзүүлж өгнө үү. 	
--	--	---	--

ХЯНАСАН

Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын Дарга

БИЕЛЭЛТ ГАРГАСАН

Б.ДОЛГИОН

Эдийн засагч, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

